

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул Агро ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код:НТАГ-2024/24/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	“Б энд С аудит” ХХК-ийн захирал Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com
Улаанбаатар хот 2023 он	Ахлах аудитор: Ц.Жамъянхорол Утас: 95282528 Цахим хаяг: bcauditllc@gmail.com
	Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99075081 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХАН-УУЛ АГРО ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.ЦОГТСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03. 15 № 603
танай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-Уул Агро ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хан-Уул Агро ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний төлөвлөгөөг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Томилолт гэж зардал гарсан боловч захирал өөрөө интернэт банкаар гүйлгээг хийж 1,392.3 мянган төгрөгийн зардал гаргасан, өдөр тутмын хэвлэл захиалгад 1,621.0 мянган төгрөг, захирал өөртөө тушаал гарган урамшуулал авсан, бэлэг дурсгалын зүйл худалдан авч үргүй зардал гаргасан 5,371.0 мянган төгрөг, харилцахаас өөртөө чек бичиж бэлэн мөнгө авч хяналтгүй зарцуулсан, бэлнээр төлбөр хийх шаардлагагүй 122,924.3 мянган төгрөгийн шатахуун, сэлбэг, дугуй, гэрээт ажлын хөлс, бараа материал, цалин хөлс, урамшуулал олгох зэргээр бэлэн мөнгийг хяналтгүй зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлангүй 54,558.9 мянган төгрөгийг шилжүүлгийн баримтаар ажил гүйлгээг бүртгэж шууд зардалд бичсэн, байгууллагын дарга өөрийн төрсөн хүүхдийг автомеханикчаар ажиллуулж 11,000.0 мянган төгрөгийг цалин хөлсийг бэлнээр олгосон зэрэг зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд, байгууллагын даргын 2022 оны А/21 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дүүргийн Засаг даргатай байгуулсан "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-ний холбогдох

заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус хэлтсийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2023.01.01	2023.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	97,320,310.65	372,017.92
1.1.2	Дансны авлага		
1.1.4	Бусад авлага		5,950,000.00
1.1.6	Бараа материал	47,456,783.00	27,214,905.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	144,777,093.65	33,536,922.92
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	722,348,729.59	1,567,838,897.32
1.2.2	Биет бус хөрөнгө	242,000.32	
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	9,695,000.00	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	732,285,729.91	1,567,838,897.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	877,062,823.56	1,601,375,820.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр		132,878,500.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	668,990,208.33	1,405,347,916.55
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	668,990,208.33	1,538,226,416.55
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	668,990,208.33	1,541,188,382.90
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	419,731,271.00	419,731,271.00
2.3.2	Хувийн өмч		
2.3.10	Хуримтлагдсан ашиг	(211,658,655.77)	(356,581,867.31)
2.3.11	Эздийн өмчийн дүн	208,072,615.23	63,149,403.69
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	877,062,823.56	1,601,375,820.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,409,405,305.00	2,359,060,141.78
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	2,409,405,305.00	2,359,060,141.78
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,404,986,980.44	2,494,055,478.27
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,418,324.56	(134,995,336.49)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,418,324.56	(134,995,336.49)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,418,324.56	(134,995,336.49)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.3	Бусад олз (гарз)	260,718,263.50	9,927,875.05
24	Орлогын нийт дүн	(256,299,938.94)	(144,923,211.54)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	419,731,271.00	44,641,283.16	464,372,554.16
C07	Тайлант үеийн үр дүн		(256,299,938.94)	(256,299,938.94)
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	419,731,271.00	(211,658,655.77)	208,072,615.23
D08	Тайлант үеийн үр дүн		(144,923,211.54)	(144,923,211.54)
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	419,731,271.00	(356,581,867.31)	63,149,403.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				төгрөгөөр/
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,343,637,180.00	2,272,896,350.00	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	446,437,230.00	332,896,350.00	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого			
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө			
1.1.4	Буцаан авсан албан татвар			
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,897,199,950.00	1,940,000,000.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого			
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,302,652,896.11	2,310,344,642.73	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	993,398,993.11	1,071,091,121.00	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	140,148,472.26	152,940,359.63	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	180,699,151.00	69,235,194.59	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	92,164,249.19	104,856,906.98	
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	546,784,181.39	651,374,619.68	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		8,842,871.96	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		5,670,637.38	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	349,457,849.16	246,332,931.51	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,984,283.89	(37,448,292.73)	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	933,900.00	59,500,000.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	933,900.00	59,500,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн			
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(933,900.00)	(59,500,000.00)	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	40,050,383.89	(96,948,292.73)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,269,926.76	97,320,310.65
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,320,310.65	372,017.92

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	1,940,160.0	2,304,632.8	(364,472.8)	118.79
1.1	Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт	1,840,160.0	2,094,450.0	(254,290.0)	113.82
1.2	Нийслэлийн санхүүжилт /ЗААлба/	100,000.0	108,402.8	(8,402.8)	108.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны орлого /ХУД ЗДТГ/		92,665.0	(92,665.0)	
1.4	Үйл ажиллагааны орлого		9,115.0	(9,115.0)	
2	Нийт зардал	1,940,127.0	2,439,628.1	(384,509.5)	119.82
2.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	1,009,500.0	1,071,091.1	(61,591.1)	106.10
2.2	ЭМД зардал	145,000.0	152,940.4	(7,940.4)	105.48
2.3	Тос, тослох материалын зардал	24,000.0	23,248.1	751.9	96.87
2.4	Байрны түрээс ашиглалт	99,000.0	101,500.0	(2,500.0)	102.53
2.5	Тээврийн хэрэгслийн оношлогоо, татварын зардал	2,000.0	593.5	1,406.5	29.68
2.6	Тээврийн зардал	1,000.0	3,911.5	(2,911.5)	391.15
2.7	Ашиглалтын зардал	8,000.0	7,819.4	180.6	97.74
2.8	Сургалтын зардал	2,000.0	200.0	1,800.0	10.00
2.9	Хангамжийн материалын зардал	15,000.0	21,311.0	(6,311.0)	142.07
2.10	Хөдөлмөр хамгааллын зардал	32,000.0	48,906.8	(16,906.8)	152.83
2.11	Шатахууны зардал	456,000.0	469,518.6	(13,518.6)	102.96
2.12	Бараа материалын зардал	10,000.0	15,570.8	(5,570.8)	155.71
2.13	Бичиг хэргийн зардал	4,400.0	4,285.6	114.4	97.40
2.14	Аудит	10,000.0	10,000.0	-	100.00
2.15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	34,000.0	64,794.3	(30,794.3)	190.57
2.16	ААНОАТатвар, татварын байгууллагад төлсөн	8,227.0	8,842.9	(615.9)	107.49
2.17	Томилолтын зардал		10,273.9	(10,273.9)	
2.19	Даатгалын төлбөрт төлсөн		5,670.6	(5,670.6)	
2.20	Хандив тусламж			-	
2.21	Сэлбэг хэрэгсэл	60,000.0	156,846.6	(96,846.6)	261.41

2.22	Шагнал урамшуулал, тэтгэмж тусламж	10,000.0	16,062.5	(6,062.5)	160.63
2.23	Машин, техник түрээсийн зардал		98,728.2	(98,728.2)	
2.24	Бусад зардал	10,000.0	127,820.6	(117,820.6)	325.21
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	33.0	19,691.7	19,691.6	
	Орлогын татварын зардал				
4	Цэвэр ашиг, алдагдал	33.0	134,995.3	(134,962.3)	
5	Хөрөнгө оруулалтын зардал			-	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 148,523.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ажилчдад илүү олгосон урамшууллыг зардлаар бүртгэсэн	1	5,950.0	1	5,950.0			1	5,950.0				
Айл өрх, албан байгууллагын хог тээврийн хураамжийг өөрийн дансанд төвлөрүүлсэн 132,878.5 мянган төгрөгийг татварын албанд төлөх өглөгөөр бүртгээгүй	1	132,878.5	1	132,878.5			1	132,878.5				
Үндсэн хөрөнгө актлахдаа дансны бичилт буруу хийсэн	1	9,695.0			1	9,695.0	1	9,695.0				
Дүн	3	148,523.5	2	138,828.5	1	9,695.0	3	148,523.5				

Аудитаар нийт 204,941.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 6,763.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 188,483.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 9,695.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолт гэж зардал гарсан боловч ямар ч анхан шатны баримтгүй, төсөв тушаалгүй зөвхөн зочид буудлын төлбөрийг захирал өөрөө интернэт банкаар гүйлгээг хийсэн	1	1,392.3	1	1,392.3								
Дүүргийн Засаг даргатай байгуулсан "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-г зөрчин байгууллагын дарга өөрийн төрсөн хүүг автомеханикчаар ажиллуулдаг мөн цалин хөлсийг бэлнээр кассаар олгодог	1	11,000.0			1	11,000.0						
Өдөр тутмын хэвлэл захиалга 1.6 сая, өөртөө тушаал гарган урамшуулал авсан 2.0 сая, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 1.7 сая нийт 5.4 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	5,371.0	1	5,371.0								
Анхан шатны баримтын бүрдэлгүй зөвхөн шилжүүлгийн баримтаар 6.8 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж шууд зардалд бүртгэсэн, Техник хэрэгсэл түрээсийн хөлс 47.7 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гүйцэтгэсэн ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	54,558.9			1	54,558.9						
Касс дах бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байхад харилцах данснаас захирал өөрийн болон нягтлангийн хувийн данс руу касс гэж татан авалт хийдэг, өөртөө чек бичиж бэлэн мөнгө авдаг, хяналтгүй	1	122,924.3			1	122,924.3						

зарцуулдаг, 146.9 сая төгрөгийг харилцахаас татан авч, бэлнээр төлбөр хийх шаардлагагүй 122,924.3 мянган төгрөгийн шатахуун, сэлбэг, дугуй, гэрээт ажлын хөлс, бараа материал, цалин хөлс, урамшуулал олгох зэргээр бэлэн мөнгөнд тавих удирдлагын хяналт тавьдаггүй												
НӨХГ-ын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө акталсан	1	9,695.0					1	9,695.0				
Дүн	6	204,941.5	2	6,763.3	3	188,483.2	1	9,695.0				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 100,286.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 100,286.9 мянган төгрөгийн төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 40.8 сая төгрөгийн 2 гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болох даргын нэг тушаал 59.5 сая төгрөгийн мэдээг байршуулаагүй байна.	1	100,286.9	1	100,286.9		
Дүн	1	100,286.9	1	100,286.9		